

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Д.Буяннэмэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
албаны сургуулийн Аюулгүй
байдлын тэнхимийн профессор,
доктор (Ph.D), хошууч

Товч утга: Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог авч үзэхийн өмнө аливаа зүйлийн тогтолцоо, түүнийг бүрдүүлэгч хэсгийн талаар судлах нь чухал юм. Тогтолцоо нь ямагт явцуу ойлголтоос ангид байдаг. Өөрөөр хэлбэл, өргөн хүрээг хамарсан өргөн ойлголт. Иймээс аюулгүй байдлыг хангах бодлогын эрх зүйн томоохон баримт бичигт заасанчлан үндэсний аюулгүй байдлыг хангах иргэд, иргэний нийгмийн төлөөлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны гадуур үл орхиж болохтой адил Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, хэрэгжилтээс хамааран энэхүү тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт багтах боломжийг эрэлхийлсэн болно.

Түлхүүр үг: Үндэстэн, Төр, Аюулгүй байдал, Нийгэм

Abstract: Before examining the system of ensuring national security, it is important to study the system and its constituent parts. The system is difficult to understand from a narrow perspective. In other words, a broad perspective that covers a wide range. Therefore, just as the major legal documents on the policy of ensuring national security do not leave citizens, representatives of civil society, and business units working on ensuring national security outside the system of ensuring national security, the Court's decision-making bodies, depending on their functions and implementation, have sought to include them in the system.

Key words: Nation, State, Security, Society

ҮНДСЭН ХЭСЭГ

Үндэсний аюулгүй байдлыг хангах гэдэг нь хувь хүн, нийгэм, улсын аюулгүй байдалд заналхийлж буй аливаа аюулыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд чиглэсэн төрийн болон олон нийтийн байгууллага, иргэдийн Монгол Улсын үндэсний эрх ашгийг хамгаалахын тулд явуулж байгаа зорилготой, зохион байгуулалттай үйл ажиллагаа юм¹.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал² “Дотоод аюулгүй байдал”-ын хэсгийг боловсруулахдаа “Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлэх, хууль ёс, үндэсний эв нэгдлийг сахин дээдлэх, Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл, мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” гэсэн агуулгад тулгуурласан байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагад байгаль орчныг хамгаалах, гааль, дипломат, гамшгаас хамгаалах, татвар, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхлэх, цагдаа, тусгай албадууд болон зэвсэгт хүчин бусад цэргийг багтаасан байдаг.

Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын тогтолцоонд багтаагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэдэг, төрийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Төрийн цэргийн байгууллага юм.

Шүүхийн шийдвэр бүрэн биелснээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулсан хариуцлагыг бүрэн эдлүүлэх зэргээр нийгэмд шударга ёс тогтоох, иргэдийн төрд итгэх итгэл дээшлүүлэх, улмаар ардчиллын үндсэн зарчим бэхжүүлэх үйл явцад чухал байр суурь эзэлдэг.

Гэвч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлангаас үзэхэд хорих ял шийтгүүлсэн 4157 хоригдол, торгох ял эдэлж буй 8175, нийгэд тустай ажил хийлгэх ял эдэлж буй 1552, зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй 1761 ялтан, тэнссэн 2126, ял хойшлуулсан 157, хугацаанаас өмнө

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал. -Уб., 2022. 42 дахь тал.

² Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан.

суллаж хяналт тогтоосон 1956 буюу нийт 19884¹ этгээдэд ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Харин иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад 2023 онд 2.6 их наяд төгрөгний өр төлбөр барагдуулахаас мөнгөн дүнгийн бодит биелэлт 29.8 хувь, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад 2096 шүүхийн шийдвэрийн 22 тэрбум төгрөгний төлбөр барагдуулахаас мөнгөн дүнгийн биелэлт 7.7 хувь байгаа нь шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзлээ.

Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт нь үндэсний аюулгүй байдал, тухайлан дотоод аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх, дотоод аюулгүй байдлыг хангахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оролцоог онол, практикийн хувьд судалж, улмаар гүйцэтгэх чиг үүргийг нь тодорхойлох шаардлага урган гарч ирж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 1921 онд Ардын хувьсгал ялж Монгол Улс тусгаар улсаа зарлан тунхагласан үеэс цэргийн цол, дүрэмт хувцсыг хэрэглэж ирсэн бөгөөд өнөөдрийг хүртэл 100 гаруй жилийн хугацаанд тасралтгүй цэргийн байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн түүхэн уламжлалтай ба бүхий л цаг хугацаанд улсын дотоод аюулгүй байдлыг хангах, шударга ёсыг сахиулах, хүний эрхийг хамгаалах, эрх зүйт төрийг бэхжүүлэх чиглэлд тодорхой үүрэг гүйцэтгэж үндсэн чиг үүргээ цэргийн алба хаагчдын хүчээр хэрэгжүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, байгууллагын бүтэц, тогтолцоо, цэргийн албаны зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

Нэг. Эрх зүйн үндэслэл.

1.1. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь хэсэгт “Цэргийн байгууллага” гэж “Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэгтэй, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг” гэж заажээ.

Хуулийн энэхүү зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзвэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэг бүхий байгууллага юм. Өөрөөр хэлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр, бусад тусгай чиг үүрэг бүхий байгууллагад багтсан онцгой объектын аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ гэмт хэрэг зөрчил үйлдсэн хүмүүсийг нийгмээс тусгаарлаж, тэдгээрийг нийгэмд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хорихоос өөр төрлийн ял, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх замаар ард

¹ ХЗДХЯ. Гэмт хэргийн цагаан ном-2023. –Уб., 2023. 84 дэх тал.

иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг цэргийн алба хаагчийн хүчээр хэрэгжүүлэхдээ үйл ажиллагаа нь эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр зохицуулагдаж байна. Тус байгууллагын офицер, ахлагч нарын аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах, иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах өдөр тутмын бүхий л үйл ажиллагаа нь эрх зүйн нийтлэг хэм хэмжээ буюу холбогдох эрх зүйн акт, хууль тогтоомжоор бүрэн зохицуулагддаг.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь хэсэгт заасан цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг цэргийн байгууллага гэж захаар зохицуулсан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 1921 оноос цэргийн цол, дүрэмт хувцсыг хэрэглэж ирсэн бөгөөд өнөөдрийг хүртэл 100 гаруй жилийн хугацаанд тасралтгүй цэргийн байгууллагын статустайгаар, цэргийн албаны сахилга бат, зохион байгуулалтад суурилан үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

1.2. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна” гэж заасан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хуулиар хүлээсэн чиг үүрэг нь эх орон, төр, ард түмнээ хүндэтгэн дээдлэх, өргөсөн тангарагтаа үнэнч байх, хууль тогтоомж, албан тушаалын үүргээ биелүүлэх, захирах, захирагдах зарчмыг мөрдөх, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, мэдлэг, мэргэшлийн түвшнээ ахиулж байх зэрэг үүргийг цэргийн эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлон бусад цэргийн байгууллагын адил дагаж мөрдөж байна. Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт 213 эрх зүйн акт /дүрэм, журам, заавар, стандарт/ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Дээрх дүрэм, журам зааврын 50-60 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх тэр дундаа иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах, хорих анги, байгууллага бүхий онцгой объектыг цэргийн сахилга бат, зохион байгуулалтын хүрээнд хамгаалах, харуул манааны үүргийг журамлахад чиглэгдэж, “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг мөрдлөг болгон ажиллаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Цэргийн цол олгох журам”-ыг баримтлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад цэргийн цол олгодог. Тус зарлигийн нийтлэг үндэслэлийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт цэргийн цол олгох харилцааг зохицуулахаар зааж өгсөн ба энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч цэргийн цол хэрэглэх нэг үндсэн эрх зүйн үндэслэл болдог.

Мөн нийт алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийг хангах, түүнийг зохион байгуулах, түвшинг тогтоох, шалгах, үнэлэхэд Зэвсэгт хүчний жанжин штабын

даргын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/505 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн бие тамирын бэлтгэлийн стандарт”-ыг баримталж байгаа бөгөөд энэ нь Батлан хамгаалах тухай хуульд заасан цэргийн байгууллагын тодоройлолтод нийцэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цэргийн байгуулалд гүйцэтгэх нэг үүрэг бол Нэгдсэн Үндэсний Байгууллагын Энхийг дэмжих ажиллагаанд 2008 оноос эхлэн алба хаагчид оролцож иржээ.

Тухайн энхийг дэмжих ажиллагаанд байгууллагын бие бүрэлдэхүүн оролцохдоо олон улсын цэрэг, энх-тайвны үйл хэрэгт байгууллагын үйл ажиллагааны онцлог буюу дүрвэгсдийн хуарангийн харуул хамгаалалт, хуяглан хүргэлт, цувааны хамгаалалт болон бусад үүргийг гүйцэтгэж ирсэн. Өнөөгийн байдлаар 120 гаруй офицер, ахлагч Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд багтан олон улсад албан үүргээ нэр төртэй гүйцэтгэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 278 дугаар зүйлийн 278.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь цэргийн цол, дүрэмт хувцастай байна” гэсэн заалтыг үндэслэн алба хаагчид цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэж иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цэргийн алба хаагчийн хүчээр хэрэгжүүлдэг.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт “цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагч” нар цэргийн тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй байхаар хуульчилсан. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал цэргийн алба хаагчийн эрх зүйн байдалтай нэгэн адилаар зохицуулагдаж байгаа нь Монгол Улсын түүхийн 100 гаруй жилийн хугацаанд тасралтгүй уламжлагдан баримталж ирсэн зохицуулалт юм.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “галт зэвсэг хэрэглэх эрхтэй” гэх зохицуулалтыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 285 дугаар зүйлийн 285.5 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй” гэж заасны дагуу хорих анги, цагдан хорих, баривчлах байр болон бусад онцгой объектын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагч, цэргийн алба хаагчтай нэгэн адил галт зэвсэг хэрэглэх эрхийг хуулиар олгогджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хоорондын харилцаандаа “Цэргийн албаны дотоод дүрэм”, онцгой объектийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа, хамгаалалтын ажилтны ээлж хүлээлцэхэд “Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм”, алба хаагчийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн, жагсаалын үзлэг явуулахад “Цэргийн жагсаалын дүрэм”, сахилга, ёс зүйн зөрчил

болон албаны хариуцлага, дэг журмыг сахин биелүүлэхтэй холбогдсон харилцааг “Цэргийн сахилгын дүрэм”-ийг баримтлан шийдвэрлэж байгаа нь цэргийн байгууллагуудтай нэгдмэл байгааг харуулж байна.

Хоёр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын”төрийн цэргийн байгуулал”-д багтсан үндэслэл:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1 дүгээр зүйлийн 1.1.5 дахь хэсэгт “Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан, уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна”, 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” гэж тус тус заасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй бүх төрлийн гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, гэмт буруутай нь шүүхээс тогтоогдож хорих ял шийтгүүлсэн этгээд болон зөрчлийн хэрэгт шийтгэгдсэн хүнийг холбогдох хуулийн хүрээнд нийгмээс тусгаарлах чиг үүргийг хэрэгжүүлж, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангах тогтолцоонд чухал байр суурийг эзэлдэг.

Өөрөөр хэлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах, гэмт халдлага, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, хор уршгийг бууруулах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү чиг үүргийг цэргийн албаны сахилга бат, зохион байгуулалтад тулгуурлан хэрэгжүүлдэг нь тус байгууллагыг “Төрийн цэргийн байгуулал”-д хамаарч буй нь зүй ёсны болохыг илэрхийлж байна.

Тус байгууллагын алба хаагчид бусад цэргийн байгууллагын нэгэн адил байлдааны цагийн үүрэгтэй ижил түвшний үүрэг гүйцэтгэдэг бөгөөд шүүхийн бүх төрлийн шийдвэрийг албадан гүйцэтгэхдээ хууль сахиулах буюу хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхийн зэрэгцээ иргэн, хоригдол, алба хаагч, түүнчлэн хорих анги, цагдан хорих, баривчлах байр, бусад онцгой объектын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг байлдааны цагийн зарчмаар цэргийн хүчээр гүйцэтгэдэг. Учир нь объектын аюулгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 24 цагийн харуул манааны үүргийг цэргийн алба хаагчид галт зэвсэг, тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан тасралтгүй гүйцэтгэж хэвшсэн.

Өнөөгийн байдлаар тус байгууллага нь нийт 3200 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 4000 гаруй хоригдол, 1000 орчим хоригдогч, 300 гаруй баривчлагдсан этгээд, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 12000, албадлагын арга хэмжээ авагдсан 7000, нийт 24000 гаруй хүнд хяналт тавин ажиллаж байна.

Улс оронд хямралт буюу дайны байдал зарлаж онцгой нөхцөл байдалд

шилжсэн үед нэгдсэн штабын бүрэлдэхүүнд буюу зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд багтан үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Ийм нөхцөл байдал бий болоход өөрийн хариуцсан онцгой объектын аюулгүй байдлыг бүрэн хангахын зэрэгцээ дайны байдлаас хамааран байгуулсан тусгаарлах байрны аюулгүй байдлыг хангах, олзлогсдыг хорих, дүрвэгсдийг нүүлгэн шилжүүлэх, хуяглан хүргэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг нэмэлт чиг үүрэгт ажиллах, дайчлагдах, бусад цэргийн болон тусгай чиг үүргийн байгууллагуудад шаардлагатай дэмжлэг үзүүлэн ажиллах хэрэгцээ, шаардлага үүсэх юм.

Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага орон нутгийн хамгаалалтад хуульд заасан чиг үүргийн хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хүн хүч, машин техник болон бусад чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Гурав. Үндэсний Аюулгүй байдлыг хангахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэж буй үүрэг

Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалд “Дотоод аюулгүй байдал”-ын хэсгийг боловсруулахдаа Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлэх, хууль ёс, үндэсний эв нэгдлийг сахин дээдлэх, Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс болох агуулгад тулгуурлажээ. Үндэсний аюулгүй байдлыг хангах олон улсын практикт үндэсний аюулгүй байдлын тэргүүн зэрэгт дотоод аюулгүй байдлын асуудал тавигддаг бөгөөд аливаа улс орны нийгмийн зөвшилцөл, тогтвортой байдал нь дотоод аюулгүй байдлын цөм болдог хамаарлаар дотоод аюулгүй байдлын хэсэг нь шинээр томъёологдсон асуудал юм.

Монгол Улсын нийгэм, төр, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар дотоод аюулгүй байдал баталгаажих харилцан хамааралтай .

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж, нийгмийн дэг журам тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” гэж тодорхойлсон.

Монгол Улсын дотоод аюулгүй байдал нь дараах үндсэн тулгуур асуудлаас бүрдэнэ. Үүнд:

- Үндсэн хуульт байгуулалыг баталгаажуулах;
- Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх;
- Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх;

- Нийгмийн тогтвортой байдал.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг дотоод аюулгүй байдлыг хангахад хэрхэн нөхцөлдөж байгааг судлан үзье.

Үндсэн хуульт байгуулалыг бататган бэхжүүлэх хүрээнд:

Үндсэн хуульт байгуулал нь сул, үйл ажиллагаа нь тодорхойгүй, төлөвшин тогтоогүй байх зэрэг нь улс орны дотоодод хямралт байдал, зөрчил тэмцлийг бий болгодог.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн чиг үүрэг болох хуулийн хүчин төгөлдөр эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэж, төрийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй буюу үйл ажиллагаа нь сул байгаа нь Үндсэн хуульт байгууллыг бэхжүүлэхэд нөлөө үзүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үүсгэн байгуулагдсан цагаас хууль дээдлэх, хүний эрхийг хангах, шударга ёсыг бэхжүүлэх үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэсээр ирсний зэрэгцээ эх орны бүтээн байгуулалт, эдийн засгийн хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр оруулсаар ирсэн. Мөн хуулийн хүчин төгөлдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

Өнөөгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх зорилгыг урдаа тавин төрийн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тус байгууллага хүний үндсэн эрх, эрх чөлөө, угаас заяасан нэр төрийг нийтээр хүндлэн сахих, хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, эрүүгийн ялын зорилгыг хангах, иргэн, захиргаа, эрүү, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр болон хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах чиг үүргийг тэргүүлэх чиглэлээ болгон ажилладаг.

Сүүлийн жилүүдэд нийгэмд төр, засгийн нэр хүнд илтэд унаж, Үндсэн хуульт байгуулалд эргэлзэх байдал онцгой анхаарал татахуйц сэдэв болж байгааг дотоод аюулгүй байдлын үүднээс авч үзэх, учир шалтгааныг хэлэлцэн тогтох, даван туулах шаардлага шинэ сорилт бий болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “шүүх эрх мэдлийг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааг явуулж байна.

Улсын хэмжээнд 2002 онд эрүүгийн 9183, иргэний 24100 нийт 33283 хэрэг, маргаан шийдвэрлэж байсан бол 2022 онд эрүүгийн 14202 буюу 64.6 хувиар, иргэний 57633 буюу 41.8 хувиар, захиргааны 2096 буюу нийт 73931 хэрэг буюу 45 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гаржээ.¹

Шүүхийн шийдвэр гэдэг нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий төрийн байгууллагаас гаргасан, эрх зүйн харилцааг тодорхойлох, түүнийг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэх хэлбэрээр тухайн хэрэг, маргаанд хамааралтай этгээдэд хуулиар тодорхойлогдсон хүсэл зоригийг илэрхийлдэг акт бөгөөд зөрчигдсөн буюу маргаантай эрхийг сэргээх, зохих ёсоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон нийт иргэдэд хүмүүжлийн үр нөлөө үзүүлэх зорилготой.²

Шүүхийн шийдвэр заавал хэрэгжих зарчмын зорилго нь шүүх эрх мэдлийн үйл ажиллагааг баталгаажуулах, түүний үр нөлөөг хүчирхэгжүүлэхэд чиглэгддэг. Энэ нь Шүүхийн тухай болон хэрэг, маргаан шийдвэрлэдэг тус тусын хуулиудад зохицуулагдсан нийтлэг зарчим юм.

Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан нь хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг аливаа байгууллага, албан тушаалтан бусад этгээдийн зүгээс өөрчлөх, хүчингүй болгох эрхгүй байх, шүүхийн шийдвэрийг зөрчсөн ямар нэгэн шийдвэр гаргахгүй байх явдлаар тодорхойлогдоно.³

Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх хүрээнд:

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс болно гэж заасан.

Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулагч нь төр байсаар ирсэн. Харин төр хариуцлагагүй, хаалттай, чадваргүй болвол үндэсний аюулгүй байдалд төр өөрөө аюул занал учруулах эрсдэлтэй.

Сүүлийн үед төрийн албанд ашиг сонирхлын зөрчил газар авч сонгуулийн дөрвөн жилийн давтамжинд төрийн алба хаагчдыг олноор солих, улс төрийн шинжтэй томилгоо хийгдэх асуудал газар авах хандлага бий боллоо. Ингэснээр мэргэшсэн чадварлаг алба хаагчийн хүрээ хумигдаж, тэдний ёс зүй, ажлын гүйцэтгэл доройтсоны улмаас иргэдийн төр, хууль ёсыг дээдлэх үзэл санаа алдагдахад хүрч байна. Энэ нь хэсэг бүлэг хүн, нам эвсэлд ашигтай хэдий ч алс хэтдээ улс орны аюулгүй байдалд асар их хор хохиролтой.

¹ Шүүхийн ерөнхий зөвлөл. Шүүн таслах ажиллагааны тайлан.

² <https://legalinfo.mn/mn/>.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. -Уб., 2014. 55 дахь тал.

Нөгөөтэйгүүр Захиргааны хэргийн Шүүхийн шийдвэр хангалтгүй биелэгдсэнээр Шүүх засаглалд иргэд үл итгэх болж, эрх мэдэл, эд хөрөнгө, танил талтай нэгэнд үйлчилдэг гэх ойлголт нийгэмд бий болж төрийн албаны залгамж чанар алдагдахад нөлөөж байна.


Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хуулийн хүчин төгөлдөр болсон шүүгчийн захирамж, хялбаршуулсан журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шүүхийн зардал тогтоосон шүүгчийн захирамжийг гүйцэтгэхтэй холбоотой харилцаа багтана.

Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш тус шүүхэд зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргах иргэн, хуулийн этгээдийн тоо жилээс жилд өсч, цаашдаа нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улсад захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж ирсэн буюу 2004 онд 145 хэрэг, маргаан шийдвэрлэж байсан бол 2022 онд 2096 буюу 15 дахин өссөн ба иргэд захиргааны хэргийн шүүхэд хандах, иргэний эрхийн үндсэн хамгаалалт болж чадсаныг харуулж байна. Өөрөөр хэлбэл, эрх мэдэлтний хууль бус шийдвэрийг захиргааны хэргийн шүүхэд мэдүүлж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах иргэдийн тоо олширч, эрх зүйн ухамсар ч дээшилсэн.


Захиргааны шүүх байгуулагдан 18 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж, төлөвшиж байгаа боловч шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байгаа нь анхаарал татаж байна. Учир нь шийдвэрийг ихэнхи тохиолдолд хууль дээдлэх, ард түмэнд үйлчлэх тангараг өргөсөн зарим байгууллага, албан тушаалтан гүйцэтгэхгүй байгаа нь шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хууль зүйн хариуцлага муу, шүүхийг үл хүндэтгэж байгаа хэлбэр гэж үзэж болохоор байна.

Зураг 1. Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа:




Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичгийн мөнгөн дүн жил ирэх тусам өсч байгаа ба 2011 онд 54.668.6 сая төгрөг байсан бол 2022 онд 22.059.551.8 тэрбум төгрөг болж өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудасны бодит биелэлт /хувиар/:



Зураг 3. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мөнгөн дүнгийн бодит биелэлт /хувиар/:



Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий алба нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газрын харьяаны агентлагийн бүтцэд байгаа нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчимд нийцэхгүй тул иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас салгаж, шүүх эрх мэдлийн байгууллагын харьяанд шилжүүлэн, шүүх мэргэжлийн удирдлагаар хангах, шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавидаг эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Захиргааны шүүхийн шийдвэрийг гүйцэтгээгүй албан тушаалтанд хүлээлгэх торгуулийн үнийн дүн захиргааны албан тушаалтанд бодитой нөлөөлөл болж чадахгүй байна. Түүнчлэн албан тушаалтан шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг үл тоох, хэрэгсэхгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, төрийн өндөр албан тушаалтан шийдвэр гүйцэтгэгчийг дарамтлах, шахалт үзүүлэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоо үгүй байна.

Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх хүрээнд:

Дотоодын улс төр, эдийн засаг, шашны хуваагдал, бүлэглэлүүдийн өрсөлдөөн, баян ядуугийн ялгаа газар авч, үндэсний нийтлэг эрх ашгийг хөсөрдүүлэх, эв нэгдлийг сарниулах улмаар нийгмийн тогтвортой байдалд заналхийлэх түвшинд хүрч байна. Дотооддоо эв нэгдэлгүй байх нь улс үндэстэн сүйрлийн ирмэгт ирж,

үндэс угсаагаараа аюулд учирч байгаагийн тод жишээг ойрх дорнодын улс орнуудаас харж болох юм.

2014-2022 онд Төрийн улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлж байсан 117 этгээд ял эдэлсэн ба судалгаанаас үзэхэд шүүхээс хорих ял шийтгэгдэх байдал жил ирэх тутам өссөн байна¹. Тус хоригдлуудын хувьд өөрийн үйлдсэн гэмт хэргийг хүлээн зөвшөөрдөггүй, улс төрийн ашиг сонирхлын үүднээс зохиомол гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн гэх үзэл бодол, яриа өгүүлэлтэй байдаг ба хорих ангиас суллагдмагц төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй эрх мэдэлтнүүдийн эсрэг үйл ажиллагаа зохион байгуулна гэх хандлага, үзэл санааг тээж байдаг нь үндэсний эв нэгдлийг сарниулах, нийгмийн талцуулах аюул заналыг бий болгож байдаг.

Нийгмийн тогтвортой байдлын хүрээнд:

Нийгмийн дэг журам тогтвортой байдлыг хангахад нийгмийн төлөвшил, ойлголцлыг илэрхийлдэг нийгмийн харилцааны баялагийг бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангахад онцгойлон анхаарч, түүнийг дотоод аюулгүй байдлыг хангах суурь асуудалд үнэлсэн нь Монгол Улсын өнөөгийн бодит шаардлага, үндэсний язгуур ашиг сонирхлоос урган гарч, үндэсний аюулгүй байдалд тусгалаа олжээ. Нийгмийн тогтвортой байдал ард иргэдийн сэтгэл зүйгээр баримжаалагддаг гэж болно. Өнөөгийн улс төрийн намуудын төлөвшил, тогтолцоо нь Монгол төрийг сулруулах үндсэн хэрэгсэл болж байна.

Манай улсын хувьд хорих ялаас татгалзах, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний зан байдалд тохирсон хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэглэх замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх үзэл баримтлалтай эрүүгийн хууль тогтоомжийг баталж өгсөн.

2015 оны Эрүүгийн хуульд нийт 1088 үйлдлийг гэмт хэрэгт тооцож “хорих, торгох, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх болон эрх хасах” ялын төрлийг үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулах тухай заасан байна.²

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хорих болон хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр, сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамжийг гүйцэтгэхтэй холбоотой харилцаа багтана.

Жил тутам гэмт хэргийн гаралт ихэсч буйтай холбогдон эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа ихэсч ял, шийтгэл оногдуулах байдал 2002 оныг

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. Хорих ял эдлүүлэх албаны тоо бүртгэлийн хэлтэсийн 2014-2021 оны үйл ажиллагааны тайлан.

² Жамбалрагчаа, Э, Урангоо Э. “Монгол Улсын Эрүүгийн хууль дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. ШШГЕГ-ын “Сүлд-Инфо сэтгүүл”-Уб., 2021. 53 дахь тал.

2022 онтой харьцуулахад хэрэг хянан шийдвэрлэж буй байдал 64.6 хувиар, ял шийтгэгдсэн хүний тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага анхаарах шаардлага урган гарч байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагад байгаль орчныг хамгаалах, гааль, дипломат, гамшгаас хамгаалах, татвар, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхлэх, цагдаа, тусгай албадууд болон зэвсэгт хүчин бусад цэргийг багтаасан байгаа ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь энэ тогтолцоонд багтаагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэдэг, төрийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн цэргийн байгууллага юм.

Шүүхийн шийдвэр бүрэн биелснээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулсан хариуцлагыг бүрэн эдлүүлэх зэргээр нийгэмд шударга ёс тогтоох, иргэдийн төрд итгэх итгэлийг дээшлүүлэх, улмаар ардчиллын үндсэн зарчим бэхжүүлэх үйл явцад чухал байр суурь эзэлдэг.

Энэхүү судалгааны ажлын явцад дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо гэдгийг аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийг төрийн бодлогын дагуу хэрэгжүүлдэг төр, засаг, төрийн захиргааны төв болон орон нутгийн удирдлагын төв байгууллага, тэдгээрийн мэдэлд байгаа бүтэц, хүч, арга хэрэгслийн цогц нэгдэл гэсэн тодорхойлолтой санал нэг бөгөөд энэ нь байгууллагуудын харилцан ажиллагааны хүрээнд бүрэн хэрэгжинэ.

2. Өнөөгийн практикт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, цар тахал зэрэг нь ял эдэлж буй этгээдийн сэтгэл зүйд нөлөөлж улмаар хоригдогсдын зүгээс нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал бий болгох, хорих байгууллагын ажилтан, алба хаагчдыг барьцаанд авах, бүлэглэн буюу зэвсэглэн оргох аюулт нөхцөл байдал үүссэн тохиолдолд байгууллагын аюулгүй байдал, улмаар улсын дотоод аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй бөгөөд ийм тохиолдол бий болсон тохиолдолд үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих анги, цагдан хорих байр, зэрэг улсын онцгой объектын аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүмүүсийг нийгмээс тусгаарлаж, тэдгээрийг нийгэмд дахин

гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хорихоос өөр төрлийн ял, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх замаар ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг дотоод аюулгүй байдлын Үндсэн хуульт байгуулалыг баталгаажуулах, төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх хүрээнд тодорхой үүрэг гүйцэтгэхээс гадна нийгмийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна гэж үзлээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх үүрэгт хийсэн шинжилгээ хийсний дүнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба” нэмж оруулах;

3. Гамшгаас хамгаалах, цагдаа, тусгай албадтай хорих байгууллагад онцгой нөхцөл бий болсон үеийн харилцан ажиллагааны чиглэлээр команд штабын сургуулийг тогтмол зохион байгуулж хэвших;

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад гүйцэтгэж буй үүрэг нь улс орны дотоод аюулгүй байдлыг хангахад хэрхэн холбогдож буй талаар сургалт, сурталчилгааны ажлыг явуулах хөтөлбөр бий болгох зэрэг болно.